



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/98

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Алтай сумын Оцог хадны далд уурхайд өргөдөл гомдлын хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг ханган, хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж, тайлан мэдээллийг нэгтгэн аймгийн Засаг даргын Зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэг (Н.Алтанцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Х.БАТБОЛД

Засаг даргын 2024 оны  
03 дугаар сарын 01-ний өдрийн  
А/98 дугаар захирамжийн  
хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн

ахлагч: Н.Алтанцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Геологи, уул уурхай, газрын тос, хийн хяналтын улсын байцаагч)

Ажлын хэсгийн

гишүүд: С.Сүхцэрэн (Цагдаагийн газрын Эрүүгийн тасгийн Экологийн ахлах мөрдөгч)

Б.Наранзул (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

Б.Намхайнямбуу (Ашигт малтмал газрын тосны төлөөлөгчийн газрын геологи, хайгуул хариуцсан ажилтан)

А.Цэнд-Аюуш (Нуман-Алтай ХХК-ийн захирал)

Л.Буян-Өлзий (Нуман-Алтай ХХК-ийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн

дарга: Б.Нарантуяа (Ашигт малтмал, газрын тосны төлөөлөгчийн газрын уул уурхай, аюулгүй байдал хариуцсан ажилтан)

-оОо-